



ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН
ГАЗАР

“ОРОН НУТГИЙН 2025 ОНЫ ТӨСВИЙН
ТӨСӨЛД ДҮГНЭЛТ ӨГӨХ”
ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

2024 оны 11 дүгээр сар



ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2024 оны 11 сарын 25 өдөр

Дугаар А/30

Алтай хот

Нийцлийн аудитын тайлан
баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1, 20 дугаар зүйлийн 20.1, 20.4, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2023 оны "Эрх шилжүүлэх тухай" А/102 дугаар тушаалын 4 дүгээр хавсралтын 1 дүгээр зүйлийн 1.1, 1.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Орон нутгийн 2025 оны төсвийн төсөлд дүгнэлт өгөх" нийцлийн аудитын тайланг хавсралтаар баталгаажуулсугай.

2. Аудитын тайланг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, аймаг, сумдын Засаг дарга нарт тус тус хүргүүлсүгэй.

3. Нийцлийн аудитаар өгсөн зөвлөмж, шийдвэрийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5 дахь хэсэгт заасан хугацаанд, биелэлтийг 2025 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн дотор Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, аймаг, сумдын Засаг дарга нарт тус тус зөвлөсүгэй.

4. Аудитын тайланг баталгаажуулснаас хойш 14 хоногт багтаан аудитын ажлын болон нотлох баримтыг архивын нэгж болгон байгууллагын архивд хүлээлгэн өгөхийг аудитын баг (Д.Цэрэнханд)-т үүрэг болгосугай.

5. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудитын менежер (Д.Эрдэнэчимэг)-т үүрэг болгосугай.


Г. ГҮНЖИДМАА



АГУУЛГА

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, СТАНДАРТ, АРГА ЗҮЙН ТАЛААРХ	
МЭДЭГДЭЛ.....	2
ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ.....	4
НЭГ. ТАТВАРЫН БОЛОН ТАТВАРЫН БУС ОРЛОГЫГ 1,425.2 САЯ ТӨГРӨГӨӨР	
НЭМЭГДҮҮЛЭХ БОЛОМЖ БАЙНА.	5
ХОЁР. ТӨСВИЙН ТӨСЛИЙН УРСГАЛ ЗАРДЛЫГ 4,094.4 САЯ ТӨГРӨГӨӨР, ХӨРӨНГӨ	
ОРУУЛАЛТЫН ЗАРДЛЫГ 2,760.0 САЯ ТӨГРӨГӨӨР БУУРУУЛАХААР	
БАЙНА.....	9
ГУРАВ. ТӨСВИЙН ТӨСӨЛД ШААРДЛАГА ХАНГААГҮЙ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН	
ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ ТӨЛӨВЛӨСӨН БАЙНА.	
БАЙНА.....	11
ДҮГНЭЛТ:.....	13



Товчилсон үгийн жагсаалт

ААТҮГ	Аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТТАМАТ	Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр
УИХ	Улсын Их Хурал
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани

Дүрслэл, хүснэгтийн жагсаалт

№	Тайлбар	Хуудасны дугаар
Дүрслэл 1	Аймгийн 2025 оны төсвийн харьцуулсан судалгаа, сая төгрөг	8
Дүрслэл 2	Урсгал зардлын судалгаа, сая төгрөг	9
Дүрслэл 3	Аймгийн ИТХ-ын төсвийн төлөвлөлт, сая төгрөг	13
Дүрслэл 4	Төсвийн 2025 оны урсгал зардлын бүтэц, сая төгрөг	
Хүснэгт 1	Усны нөөц ашигласны төлбөрийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл, сая төгрөг	7

Хавсралтын товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хавсралт 1	Үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар ус ашигласны төлбөрийн орлого	6
Хавсралт 2	Түрээсийн орлогын тооцоо	6
Хавсралт 3	Өмч хувьчлах хөрөнгийн жагсаалт	7
Хавсралт 4	Иргэдээс санал аваагүй төсөл арга хэмжээ	8
Хавсралт 5	Өмнөх оны шийдвэрийн хэрэгжилт	8

Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Ерөнхий аудиторов “Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай” 2023 оны А/162 дугаар тушаалыг үндэслэн аудитыг хийж гүйцэтгэлээ.

Аудитын зорилго

Аймгийн Засаг даргын өргөн мэдүүлсэн Орон нутгийн 2025 оны төсвийн төслийг арвилан хэмнэлттэй, үр ашигтай, үр нөлөөтэйгөөр боловсруулж, төрийн санхүүгийн удирдлагыг сайжруулан эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангахад чиглүүлсэн эсэхийг үнэлэх, төсвийн орлого нэмэгдүүлэх, төсвийн зарлагыг бууруулах, төсвийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэх дүгнэлт, зөвлөмж гаргахад аудитын зорилт чиглэсэн. Үүнд:

- Төсвийн орлого нэмэгдүүлэх нөөц боломж байгаа эсэх;



	➤ Төсвийн төсөлд зарлага бууруулах боломжийг бүрэн тусгасан эсэх; ➤ Төсвийн төсөл нь холбогдох хуульд заасан тусгай шаардлага, төсвийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэх боломжийг хангасан эсэх;
Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт	Аудитыг АДБОУС, Төрийн аудит MNS 6817:2020 Монгол Улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”, аудитыг гүйцэтгэх заавар, аргачлал, гарын авлагыг мөрдөж гүйцэтгэсэн.
	Аудитаар Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, ажиллагааны хөтөлбөрт тусгасан холбогдох бодлогын зорилттой уялдсан эсэх, нэгтгэсэн дүн шинжилгээ, харьцуулалт хийх, тулган баталгаажуулах, холбогдох албан тушаалтантай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга авах зэрэг аудитын горимыг хэрэгжүүлэн ажиллаж хөтөлбөр, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.
Аудитын хамарсан хүрээ	Аудитад аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын Тамгын газар, Санхүү, төрийн сангийн хэлтэс, Хөгжлийн бодлого, хөрөнгө оруулалтын хэлтэс, Татварын газар, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар болон холбогдох бусад байгууллагын аудитын сэдэвт хамаарал бүхий үйл ажиллагааг хамруулан гүйцэтгэлээ.
Талуудын хүлээх үүрэг, хариуцлага	Засаг даргаас аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлсэн орон нутгийн 2025 оны төсвийн төслийг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулсан эсэхэд аудит хийж, Төсвийн тухай хуульд заасан хугацаанд дүгнэлт гаргах нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.
Аудитын бүрэлдэхүүн, хугацаа	Аудитыг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Г.Гүнжидмаа удирдан зохион байгуулж, аудитын менежер Д.Эрдэнэчимэг чанарын хяналт тавьж, стандартыг хангуулан, ахлах аудитор Д.Цэрэнханд ахалж, ахлах аудитор М.Атарцэцэг, аудитор Н.Гэрэлмаа, Ц.Сайханжаргал, Э.Сүнжидмаа, О.Энхтөр нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэлээ.



ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуулийг 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдөр баталсан байна.

Засгийн газрын 2024 оны 07 дугаар сарын 24-ний өдрийн 10 дугаар тогтоолоор Төсвийн Ерөнхийлөн захирагч нарын 2025 оны төсвийн хязгаарыг баталжээ.

Уг тогтоолоор аймгийн нийт төсвийг 77,211.0 сая төгрөг, суурь орлогыг 30,727.5 сая төгрөгөөр, улсын төсвөөс авах санхүүгийн дэмжлэгийг 28,256.9 сая төгрөгөөр, суурь зарлагыг 58,984.4 сая төгрөгөөр тус тус тогтоосон байна.

Батлагдсан төсвийн хязгаарт нийцүүлэн 2025 оны төсвийн төслийг боловсруулахыг төсвийн Ерөнхийлөн захирагч нарт даалгасан байна.

Төсвийн Ерөнхийлөн захирагчийн 2025 оны төсвийн саналд орлогыг 24,227.6 сая төгрөгөөр, урсгал зарлагыг 76,089.8 сая төгрөгөөр тооцож Сангийн яаманд 2024 оны 07 дугаар сарын 25-нд хүргүүлсэн байна.

Сангийн яамнаас 2025 оны төсвийн орлогыг 32,135.9 сая төгрөгөөр, урсгал зардлыг 58,270.2 сая төгрөгөөр хянасан байна.

Төсвийн Ерөнхийлөн захирагчийн 2025 оны урсгал зардлыг 66,985.4 сая төгрөг буюу Сангийн яамны хянасан дүнгээс 8,715.2 сая төгрөгөөр илүү төлөвлөсөн байна.

Төсвийн орлогын 20,702.3 сая төгрөг буюу 64.4 хувийг сумдын төсөвт, 11,443.6 сая төгрөг буюу 35.6 хувийг аймгийн төсөвт төвлөрүүлэхээр тооцсон байна.

Төсвийн Ерөнхийлөн захирагчийн өргөн мэдүүлсэн төсвийн төсөлд орон нутгийн 45 төсвийн байгууллага 747 орон тоотой ажиллан, 32,135.9 сая төгрөгийн төсвийн орлогыг бүрдүүлж, үндсэн тэнцлийн алдагдал 34,310.2 сая төгрөгийг улсын төсвөөс дэмжлэгээр авч, тусгай сангаас 110.0 сая төгрөг, Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих сангийн эргэн төлөлтөөс 419.3 сая төгрөг зарцуулан, ОНХС-гийн орлогын шилжүүлгээр 24,990.2 сая төгрөг, нийт 91,975.6 сая төгрөгийн зардал гаргахаар төсөвлөсөн байна.

2025 оны төсвийн жилд дараах арга хэмжээг хэрэгжүүлэхээр байна. Үүнд:

- Төрийн албан хаагчдын цалинг 2025 оны 01 дүгээр сарын 01-ээс 6.0 хувиар нэмэгдүүлэх,
- Засгийн газрын 2024 оны 82 дугаар тогтоолын дагуу орон нутагт төрийн албан хаагчдыг тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг хангах зорилгоор 2024 оноос олгож эхэлсэн орон нутгийн нэмэгдлийн хувь хэмжээ болон хамрах хүрээг нэмэгдүүлэх,
- Цахилгаан эрчим хүчний тариф нэмэгдсэнтэй холбоотой гэрэл цахилгааны зардал болон шинээр төвлөрсөн халаалтын системд холбогдсон 1 сумын халаалтын зардал нэмэгдсэн,
- Сангийн сайдын 2024 оны А/52 дугаар тушаалын дагуу албан томилолтын зардал нэмэгдсэн.

Орон нутгийн төсвийн төсөлд ОНХС-гийн хөрөнгөөр 2025 онд 3 хөтөлбөр, арга хэмжээний 42 төсөл, арга хэмжээг 9,346.7 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөсөн.



Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2025 онд шилжих 6, шинээр эхлэх 6 төсөл, арга хэмжээг нийт 1,436.9 сая төгрөгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.

Авто замын сангийн хөрөнгөөр 2025 онд шилжих 3 төсөл, арга хэмжээ, шинээр 1 төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр 691.5 сая төгрөгийн төсөвлөсөн.



Дүрслэл № 1: Аймгийн 2025 оны төсвийн харьцуулсан судалгаа, сая төгрөг

Орон нутгийн 2025 оны төсвийн төсөл боловсруулахдаа Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар баталсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-ын (цаашид журам гэх) 7 дугаар зүйлд заасан 2 шаардлагыг хангаагүй байна. Үүнд:

- Хөтөлбөрийн зорилго, зорилт, хүрэх үр дүнгийн үзүүлэлтийг тодорхойлсон байх;
- Худалдан авах бараа, ажил үйлчилгээний төлөвлөгөөний төслийг хавсаргасан байх;

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны төсвийн төсөл нь Төсвийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1¹, 31.4²-д заасан зарчим, тооцоо судалгаанд үндэслэсэн, баримт материал иж бүрэн байх шаардлагуудыг хангахгүй байна.

НЭГ. ТАТВАРЫН БОЛОН ТАТВАРЫН БУС ОРЛОГЫГ 1,425.2 САЯ ТӨГРӨГӨӨР НЭМЭГДҮҮЛЭХ БОЛОМЖ БАЙНА.

- 1.1. Төсвийн төсөлд татварын орлогыг 31,011.7 сая төгрөгөөр, татварын бус орлогыг 1,124.2 сая төгрөгөөр тооцож төлөвлөсөн байна.
- 1.2. Орон нутгийн төсвийн төсөлд 2025 оны орлогыг 2024 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээс 6,026.9 сая төгрөгөөр нэмэгдүүлэн тооцсон байна.
- 1.3. Энэ нь цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэх орлого, хөрөнгийн орлого, ААНОАТ, автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар, үл хөдлөх хөрөнгийн албан татварын орлогыг өмнөх оны гүйцэтгэлээс нэмэгдүүлэн төлөвлөсөнтэй холбоотой байна.

¹ Төсвийн ерөнхийлөн захирагчийн жилийн төсвийн төсөл дараах шаардлагыг хангасан байна:

² Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн төсөлд дараах тооцоог хавсаргана



- 1.4. Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1³-д заасны дагуу аймгийн ИТХ-ын 2022 оны 60 дугаар тогтоолоор үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын хувь хэмжээг тогтоосон байна.
- 1.5. Сангийн яамны хянасан дүнгээр үл хөдлөх хөрөнгийн албан татварын орлогыг **15.4** сая төгрөгөөр нэмэгдүүлэх боломж байна.
- 1.6. Түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлогыг орон нутагт хэрэгжиж буй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнүүдтэй уялдуулан төлөвлөөгүй байна.
- 1.7. Татварын газар, Санхүү, төрийн сангийн хэлтсээс түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлогыг тооцоолох боломжгүй гэсэн шалтгаанаар төлөвлөөгүй байна. Тус орлогыг өмнөх оны гүйцэтгэлээр тооцоход **41.2** сая төгрөгөөр төлөвлөж, орлого нэмэгдүүлэх боломж байна.
- 1.8. Цаашид иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудаас байгалийн нөөц ашигласны төлбөрийг холбогдох хуулийн тогтоомжийн дагуу тооцож төсөвт бүрэн төвлөрүүлж, төсвийн орлогыг нэмэгдүүлэх шаардлагатай байна.
- 1.9. Газрын төлбөрийн орлогыг Сангийн яамнаас хянасан 1,376.0 сая төгрөгөөр тооцож, төсвийн төсөлд **165.0** сая төгрөгөөр нэмэгдүүлэн төлөвлөх боломж байна.
- 1.10. ГХБХБГ-аас ирүүлсэн мэдээллээр тооцоход 2025 онд газрын дуудлага худалдааны орлогыг **55.5** сая төгрөгөөр нэмэгдүүлэхээр байна.
- 1.11. Гэвч төсвийн төсөлд 139.5 сая төгрөгөөр тооцож төлөвлөсөн нь Засгийн газрын 2016 оны 10 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан “Газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах, дуудлага худалдаа явуулах журам”-ын 12.24-т заасантай нийцэхгүй байна.
- 1.12. Төсвийн төсөлд малын тоо толгойн албан татварын орлогыг огт төлөвлөөгүй байгаа нь Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1⁵ дахь заалттай нийцэхгүй байна.
- 1.13. Малын тоо толгойн албан татварын тухай хуулийг хэрэгжүүлж, орон нутагт төсвийн орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэн, татварыг ногдуулж бүрэн төлөвлөрүүлэн тулгамдсан асуудлыг шийдвэрлэх шаардлагатай байна. Тухайлбал, 2022 онд 325.2 сая төгрөг дутуу төлөвлөсөн, гүйцэтгэлээр 530.7 сая төгрөгийг дутуу төвлөрүүлжээ.
- 1.14. Иймд 2023 оны малын тоо толгойд үндэслэн албан татварыг тооцоход 1,052.2 сая төгрөгийн албан татвар ногдуулахаар байна.

³ Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварыг энэ хуулийн 5 дугаар зүйлд заасан үнэлгээнээс аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тухайн хөрөнгийн байршил, зориулалт, хэмжээ, зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн байдлыг харгалзан 0.6-2.0 хувиар тооцож ногдуулна

⁴ Аймаг, нийслэл, чөлөөт бүс тус бүр төрийн сангийн газрын биржийн тусгай данстай байх бөгөөд уг дансанд дуудлага худалдааны орлого, дэнчинг төвлөрүүлнэ”

⁵ 5.1. Албан татвар төлөгчийн өмчилж буй Монгол Улсын нутаг дэвсгэрт байгаа малын тоо толгойд албан татвар ногдуулна.



- 1.15. Харин Татварын газрын бааз сууриар тооцоход **768.8** сая төгрөгөөр малын тоо толгойн албан татварыг орлогыг төлөвлөхөөр байна.
- 1.16. Бигэр, Бугат, Дэлгэр, Шарга сумын ИТХ-аас нэг малын тоо толгойд тухайн татварын жилд ногдуулах албан татварын хэмжээг “0” төгрөг байхаар шийдвэрлэсэн нь хууль тогтоомжтой нийцэхгүй байна.
- 1.17. Үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар үйл ажиллагаа явуулдаг 21 хуулийн этгээдийн усны нөөц ашигласны төлбөр 14.6 сая төгрөг, Хан-Алтай ресурс ХХК-ийн усны нөөц ашигласны төлбөр 183.5 сая төгрөг, нийт **198.1** сая төгрөгөөр орлогыг нэмэгдүүлэх боломж байна. (дэлгэрэнгүйг хавсралт №1-оос үзнэ үү)

Хүснэгт №:1 Усны нөөц ашигласны төлбөрийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл, сая төгрөг

Он	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Зөрүү
2021 он	164.0	120.4	(43.6)
2022 он	182.8	128.7	(54.1)
2023 он	328.6	399.9	71.0
2024 он	508.1	564.8	56.7

Эх сурвалж: Аймгийн 2021, 2022, 2023, 2024 оны төсвийн гүйцэтгэл

- 1.18. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.5⁶, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2020 оны 49 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн төлбөрийн доод хязгаар, түрээсийн зарим төлбөрийн хэмжээг тогтоох заавар, улсын төсөвт төвлөрүүлэх орлогын хувь хэмжээг шинэчлэн батлах тухай” зааврын дагуу түрээсийн орлогыг тооцож, төвлөрүүлэхээр заасан байна.
- 1.19. Орон нутгийн өмчийн хөрөнгийг түрээслүүлэх журмын дагуу төрийн байгууллагуудын 4 иргэн, аж ахуйн нэгжид түрээслүүлсэн байр, талбайн түрээсийн орлогыг тооцвол **7.5** сая төгрөгөөр нэмж төлөвлөх боломж байна. (дэлгэрэнгүйг хавсралт №-2-аас үзнэ үү)
- 1.20. Аймгийн ИТХ-ын тогтоолоор өмч хувьчлалын орлогын төлөвлөгөөнд 7 барилга, 10 автомашиныг хувьчлахаар баталсан боловч хөрөнгийн доод үнийг батлаагүйгээс орлого орох боломжийг алдсан байна. (дэлгэрэнгүйг хавсралт №-3-өөс үзнэ үү)
- 1.21. Аймгийн ИТХ-ын 2023 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 67 дугаар тогтоолын дагуу Баян-Уул сумын Соёлын төвийн хуучин барилгын доод үнийг бууруулахгүйгээр 35.3 сая төгрөгөөр дуудлага худалдааг зохион байгуулснаар хөрөнгийн үр өгөөж бий болохоор байна.
- 1.22. Бусад орлогыг төсвийн төсөлд төлөвлөөгүй байна. Гүйцэтгэлээр 2022 онд 51.6 сая төгрөг, 2023 онд 271.6 сая төгрөг, 2024 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр 60.0 сая төгрөг төсөвт төвлөрөхөөр байна. Иймд өмнөх оны гүйцэтгэлээр тооцвол **60.0** сая төгрөгөөр бусад орлогыг төлөвлөж, төвлөрүүлэх боломж байна.
- 1.23. Төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогыг Сангийн яамны хянасанаар **10.3** сая төгрөгөөр төлөвлөх шаарлагатай байна.

⁶ Төрийн өмчийн түрээсийн төлбөрийг улсын төсөвт оруулна.



- 1.24. УИХ-ын гишүүдийн төсвийн багцаас 2009-2012 онд олгосон жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор иргэд, хоршоо, аж ахуй нэгжид олгосон зээлийн үлдэгдэл **103.4** сая төгрөгийн орлого нэмэгдэх боломж байна.
- 1.25. Төсвийн тухай хуульд 2020 онд орсон нэмэлт өөрчлөлтөөр тухайн аймагт бүртгэлтэй аж ахуйн нэгжийн орлогын албан татварын 40.0 хувийг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр тусгасан байна.
- 1.26. Аймгийн хэмжээнд ашигт малтмалын олборлолтын үйл ажиллагаа эрхэлж буй томоохон аж ахуйн нэгж Хан-Алтай ресурс ХХК нь ашигт малтмал хайгуул, олборлолт, үйлдвэрлэл эрхэлдэг байгууллагын үйл ажиллагааны 2023 оны тайлангаар аж ахуй нэгжийн орлогын албан татварт 15,320.5 сая төгрөгийг төлсөн байна. Үүний 40.0 хувь буюу 6,128.4 сая төгрөгийг аймгийн төсөвт төвлөрүүлэхээр байна.
- 1.27. Аймгийн дүнгээр 2024 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар аж ахуйн нэгжийн орлогын албан татварын гүйцэтгэл 1,753.5 сая төгрөг байна.
- 1.28. Төсвийн төсөлд аж ахуйн нэгжийн орлогын албан татварыг төлөвлөхдөө тооцоо судалгаанд үндэслэлгүйгээр 9,100.0 сая төгрөгөөр төсөвлөсөн нь орлогын төлөвлөгөө тасрах эрсдэл үүсэхээр байна.


ХОЁР. ТӨСВИЙН ТӨСЛИЙН УРСГАЛ ЗАРДЛЫГ 4,094.4 САЯ ТӨГРӨГӨӨР, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЗАРДЛЫГ 2,760.0 САЯ ТӨГРӨГӨӨР БУУРУУЛАХААР БАЙНА.

- 2.1. “Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2025 оны төсвийн хязгаарыг батлах тухай” Засгийн газрын 2024 оны 10 дугаар тогтоолоор төсвийн суурь зарлагыг 58,984.4 сая төгрөгөөр баталсан. Төсвийн төслөөр 66,975.6 сая төгрөг буюу төсвийн хязгаараас 7,991.2 сая төгрөгөөр хэтрүүлэн төлөвлөжээ. Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14 дүгээр зүйлийн 14.2.1⁷-д заасныг зөрчсөн байна.
- 2.2. Аймгийн 2025 оны төсвийн төсөлд нийт зарлагын дүнг 2024 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээс 4,867.3 сая төгрөгөөр буюу 7.8 хувиар нэмэгдүүлж төлөвлөсөн байна. Үүнд: Урсгал зардалд 65,706.3 сая төгрөг, хөрөнгийн зардалд 1,269.3 сая төгрөгийг зарцуулахаар тус тус төлөвлөжээ.

⁷ жилийн төсвийн хязгаарт багтаан төсвийн төслийг боловсруулах;



Дүрслэл №2. Урсгал зардлын судалгаа, сая төгрөг



2.3. Төсвийн урсгал зардлын гүйцэтгэл 2018-2024 онд дунджаар 35.3 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Дүрслэл № 3: Төсвийн 2025 оны урсгал зардлын бүтэц, сая төгрөг



2.4. Урсгал зардлын бүтцийг авч үзвэл бараа үйлчилгээний зардалд 59.2 хувийг, цалин хөлс, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардалд 40.8 хувийг зарцуулахаар байна.

2.5. Аймгийн 2025 оны төсвийн төсөлд цалин, хөлсний зардлыг 24,312.8 сая төгрөг, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 3,032.1 сая төгрөгөөр төсөвлөжээ.

2.6. Төсвийн төсөлд байгууллагаас ирүүлсэн саналд үндэслээгүй, Сангийн ямаар хянуулаагүй, тооцоо судалгаагүй, давхардуулсан 4,094.4 сая төгрөгийн зардлыг төсөвлөсөн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3⁸, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2⁹, 5.3¹⁰, 15 дугаар зүйлийн 15.1.2¹¹ дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тогтоолоор баталсан аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын захиран зарцуулах "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-тай тус тус нийцэхгүй. Тухайлбал:

- Төрийн албан хаагчид үндсэн ажлын чиг үүргээ хэрэгжүүлсэн байхад цалингаас гадна нэмэлтээр тухайлсан салбар сонгон давуу байдал үүсгэн дэмжлэг, урамшуулал олгохоор, нэг удаагийн шинж чанартай зардлуудыг төлөвлөсөн. Урсгал зардлын төсвөөс багш, ажилчдад нэг удаагийн шинжтэй шагнал, урамшуулал олгоход 2,500.0 сая төгрөг, төрийн албан хаагчдын орон сууцны дэмжлэг 1,000.0 сая төгрөг, нийт 3,500.0 сая төгрөгийн зардлыг бууруулах.

⁸ өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах;

⁹ Нийслэлийн Засаг дарга хоёр, аймаг, дүүрэг, сумын Засаг дарга нэгээс илүү орлогч даргатай байхыг хориглоно;

¹⁰ Засгийн газрын агентлагийн дарга, иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд зөвлөх чиг үүрэг бүхий орон тооны этгээд ажиллуулахыг хориглоно;

¹¹ Чиг үүрэг, орон тоог давхардуулан тогтоох;



- Аймгийн ОНХС-гаас аймгийн баяр наадмын зардлыг санхүүжүүлэхээр төлөвлөсөн байхад урсгал зардлын төсвөөс давхардуулан 200.0 сая төгрөгийг төлөвлөснийг бууруулах.
- Жангар туйл хайлах, Жангар фестиваль, залуучуудын чуулга уулзалт зохион байгуулах арга хэмжээнд 200.0 сая төгрөгийг төлөвлөсөн нь өмнөх оны гүйцэтгэлээс 100.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэн төлөвлөснийг бууруулах.
- Аймгийн ЗДТГ-ын бүтэц орон тоог 2 (Засаг даргын орлогч, зөвлөх)-оор илүү төсөвлөж, цалингийн зардлыг 119.4 сая төгрөгөөр нэмэгдүүлэн тооцсныг бууруулах.
- Аймгийн ИТХ-ын 2025 оны төсвийн төсөлд хурлын даргын нөөц хөрөнгөд 100.0 сая төгрөг, тээвэр шатахууны зардалд 75.0 сая төгрөгийг өмнөх оны гүйцэтгэлээс илүү төлөвлөснийг бууруулах.

2.7. Төсвийн төсөлд зураг төсөв, гэрээ байгуулаагүй, тогтоол шийдвэргүй, Сангийн ямаар хянуулаагүй 509.1 сая төгрөгийн зардлыг төсөвлөсөн байна. Төсвийн үр ашгийг дээшлүүлж, төсвийн хууль тогтоомжийн хүрээнд төсөвлөлтийн шаардлагыг хангуулах дараах зардлууд байна. Тухайлбал:

- Төрийн бус байгууллагын урсгал үйл ажиллагааны зардалд 279.1 сая төгрөгийн дэмжлэг олгохоор төлөвлөсөн.
- Аймгийн ИТХ-ын урсгал засварын зардалд 50.0 сая төгрөг, аймгийн ЗДТГ-ын урсгал засварын зардалд 180.0 сая төгрөгийг тус тус төлөвлөсөн.

2.8. Эдгээр хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхээр төсөвлөсөн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1¹², 14 дүгээр зүйлийн 14.2.1¹³ дахь заалтуудтай нийцэхгүй байна.

2.9. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотойгоор зардлыг хэрэгцээ, шаардлагад үндэслэн эрэмбэлэн төлөвлөх шаардлагатай байна.

2.10. Өмнөх оноос аймгийн ЗДТГ-ын төсвийг 5.5 хувиар, сумдын ЗДТГ-ын төсвийг 1.1 хувиар, аймгийн ИТХ-ын төсөв 75.0 хувиар тус тус нэмэгдүүлж, сумдын ИТХ-ын төсвийг 2.5 хувиар буурахаар төлөвлөжээ.

Дүрслэл № 4: Аймгийн ИТХ-ын төсвийн төлөвлөлт, сая төгрөг (2018-2025 он)



¹² төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах

¹³ жилийн төсвийн хязгаарт багтаан төсвийн төслийг боловсруулах



- 2.11. Аймгийн ИТХ-ын төсөв 2018-2024 онд дунджаар 14.0 хувиар өссөн байна. Гэвч 2025 оны төсвийн төсөлд 75.0 хувиар нэмэгдүүлэн төсөвлөсөн байна. Цалин, хөлсний зардал 249.8 сая төгрөг буюу 26.5 хувиар, бараа үйлчилгээний бусад зардал 690.6 сая төгрөг буюу 73.5 хувиар нэмэгдсэн байна. Бараа үйлчилгээний бусад зардлыг төлөвлөхдөө байгууллагаас ирүүлсэн санал, хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээний төсөв, тооцоо судалгаанд үндэслээгүй байна.
- 2.12. Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулиар аймгийн нийт 66,446.3 сая төгрөгөөр баталсан бөгөөд Монгол Улсын Ерөнхийлөгч бүхэлд нь хориг тавьсан.

ГУРАВ. ТӨЛӨВЛӨЛТИЙН ШААРДЛАГА ХАНГААГҮЙ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ ТӨЛӨВЛӨСӨН БАЙНА.

- 3.1. Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас 2025 онд 24,990.3 сая төгрөгийн орлогын шилжүүлэг, шилжих үлдэгдлээс 307.7 сая төгрөг, нийт 25,307.9 сая төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлэхээр төлөвлөсөн байна. Үүнээс сумдын ОНХС-д 16,268.8 сая төгрөгийг, аймгийн ОНХС-д 9,039.1 сая төгрөгийг олгохоор төлөвлөжээ.
- 3.2. Аудитад аймгийн ОНХС-гийн хөрөнгө оруулалтын жагсаалт хамрагдсан бөгөөд сумдын ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалт, шаардлагатай баримтуудыг ирүүлээгүй. Цаашид төсөв боловсруулж, өргөн мэдүүлэхдээ хуульд заасан төсөвлөлтийн шаардлагыг хангасан төсөл, арга хэмжээг тусгах, төсвийн үр өгөөжийг нэмэгдүүлэхийн тулд баримт, материал, үндэслэл тооцоололд нийцүүлэх шаардлагатай байна.
- 3.3. Аймгийн ОНХС-гийн санхүүжилтээр 2025 онд 12,952.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 42 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Үүнээс шилжих 2,383.9 сая төгрөгийн 16 төсөл, арга хэмжээг санхүүжүүлж, 2025 онд 9,039.1 сая төгрөгөөр шинээр хэрэгжих 25 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.
- 3.4. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2025 онд 3,051.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 12 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс он дамжин хэрэгжиж буй 7 төсөл, арга хэмжээг 2,302.3 сая төгрөгөөр, шинээр хэрэгжих 5 төсөл, арга хэмжээг 748.8 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр тусгажээ.
- 3.5. Авто замын сангийн санхүүжилтээр 2025 онд 4 төсөл, арга хэмжээг 1,437.1 сая төгрөгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Үүнээс шилжих ОНХС-гийн эх үүсвэрээс хэрэгжиж үлдэгдэл санхүүжилтийг олгохоор 3 төсөл, арга хэмжээг 952.6 сая төгрөгөөр, шинээр хэрэгжих 1 төсөл, арга хэмжээг 484.5 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр тусгажээ.
- 3.6. Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлд заасан төлөвлөлт үр дүнд чиглэсэн, зорилго зорилт нь хэмжигдэхүйц байх зарчим, Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29^{1.1}¹⁴, 31 дүгээр зүйлийн 31.1.2¹⁵,

¹⁴ Төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх барилга байгууламжийн төсөл, арга хэмжээ нь энэ хуульд заасан шаардлагад нийцсэн, холбогдох аргачлалын шалгуур үзүүлэлтээр үнэлгээ өгч эрэмбэлсэн, эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдол бүхий төслүүд байна

¹⁵ хөтөлбөрийн зорилго, зорилт, хүрэх үр дүнгийн үзүүлэлтийг тодорхойлсон байх



Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.4¹⁶-д төсвийн шаардлага хангасан хөрөнгө оруулалтын арга хэмжээг төлөвлөхөөр заасан.

- 3.7. Төсвийн төсөлд тусгасан төсөл, арга хэмжээний хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлт, нийгмийн ач холбогдол, эдийн засгийн үр ашиг, хөрөнгө оруулалтын өгөөжийг тооцоогүй байна.
- 3.8. Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн 2025 оны хөгжлийн төлөвлөгөө батлагдаагүй тул хэрэгжүүлэх арга хэмжээ нь дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт нийцэж байгаад дүгнэлт гаргах боломжгүй байна.
- 3.9. Төсвийн төсөлд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ нь холбогдох хууль тогтоомжид заасан шалгуур хангасан эсэхийг авч үзэхэд дараах байдалтай байна.

Орон нутгийн хөгжлийн сан:

- Төрийн албан хаагчдыг орон сууцжуулах төсөл, арга хэмжээг 2,760.0 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөсөн нь Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2, 4.7.6-т¹⁷ заасантай нийцээгүй, хөрөнгийг үр ашиггүй зарцуулах нөхцөл үүссэн.
- Шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 2,933.7 сая төгрөгийн 15 төсөл, арга хэмжээ иргэдийн санал аваагүй нь Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3.6-т¹⁸ заасан шаардлагыг хангахгүй байна. (дэлгэрэнгүйг хавсралт №4-өөс үзнэ үү)
- Аймгийн ОНХС-гаас хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 1,149.0 сая төгрөгийн өртөгтэй 6 төсөл, арга хэмжээ зураг төсөв, техник, эдийн засгийн үндэслэлгүй, 3,394.7 сая төгрөгийн 17 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлсний дараах өмчлөл, ашиглалтын зардлыг тооцоогүй нь Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалын хавсралтын 4 дүгээр зүйлийн 4.1.2-т¹⁹, 4.1.3-т²⁰, 4.7.5-т²¹ заасан шаардлагыг хангахгүй байна.
- Хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтыг нийтэд нээлттэй хэлэлцүүлээгүй, Засаг даргын зөвлөлийн хурлаар нэгдсэн жагсаалтыг хугацаа хоцроож хэлэлцүүлсэн нь “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 7.5²², 7.6²³, -д заасныг тус тус зөрчсөн байна.

¹⁶ ОНХС-ийн зорилго нь орон нутгийн хөгжлийг дэмжих, бүс нутгийн хөгжлийн тэнцвэртэй байдлыг хангах, иргэдийн тогтвор суурьшилтай амьдрах орчин, нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэгдэнэ

¹⁷ “Аливаа аж ахуйн нэгж, байгууллага, иргэнд олгох буцалтгүй тусламж, дэмжлэг, тэтгэмж, урамшуулал”

¹⁸ “Орон нутгийн иргэдийн саналыг аваагүй, орон нутгийн төсвийн төлөвлөгөөнд тусгаж батлаагүй зардал, арга хэмжээ”,

¹⁹ “Сум, дүүргийн иргэдээр дэмжигдсэн сум, дүүргийн төсвөөр бие даан хэрэгжүүлэх боломжгүйгээс аймаг, нийслэлийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр хүргүүлсэн жагсаалтад орсон байх”,

²⁰ “ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь хуульд заасны дагуу зураг төсөв, техник, эдийн засгийн үндэслэлтэй, байгаль орчны төлөө байдлын үнэлгээ хийгдсэн, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон байх”,

²¹ “Орон нутгийн иргэдийн саналыг аваагүй орон нутгийн төсвийн төлөвлөгөөнд тусгаж батлаагүй зардал, арга хэмжээ”,

²² Урьдчилан жагсаалтыг аймаг, нийслэлийн Иргэний танхимаар дамжуулан нийтэд зар мэдээ хүргээний үндсэн дээр нээлттэй хэлэлцүүлгийг жил бүрийн 7 дугаар сард багтаан зохион байгуулна.

²³ Ажлын хэсэг хэлэлцүүлгийн үр дүнг нэгтгэн аймаг, нийслэлийн ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний нэгдсэн жагсаалтыг ОНХС-ийн УМС-ийн маягтын дагуу хэлэлж жил бүрийн 8 дугаар сарын 10-ны өдрийн дотор Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлнэ.



- Үндэсний их баяр наадмын зардлыг 200.0 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр төсөвлөсөн нь өмнөх онуудын гүйцэтгэлээс 2 дахин их байна. Энэ нь Засгийн газрын 271 дүгээр тогтоолын 2²⁴-т заасныг зөрчсөн байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт:

- Хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 132.8 сая төгрөгийн өртөгтэй 2 төсөл арга хэмжээ нь (Солонго дулааны станц" ААТҮГ-т эко хашаа шинээр барьж байгуулах ажил", "Есөнбулаг сум "Говь-Алтай аймгийн төв Алтай хотын Лодойдамбын гудамжны тохижилт, шинэчлэлтийн ажил") Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл"-д тусгагдаагүй
- Есөнбулаг сумын гэр хорооллын багт ус түгээх цэг байгуулах 64.4 сая төгрөгтэй төсөл, арга хэмжээ нь 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд тусгагдаагүй.

Авто замын сан:

- “Есөнбулаг сумын авто зогсоолуудыг өргөтгөх, шинэчлэл хийх ажил” нь төсвийн тухай хуулийн 29¹ дүгээр зүйлийн 29^{1.2}, Авто замын тухай хуулийн 24 дүгээр зүйлд заасан шалгууртай нийцээгүй.

3.10. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хууль тогтоомжид заасны дагуу төлөвлөхгүй байгаа нь хөрөнгийн үр ашиг, үр өгөөжийг бууруулах эрсдэлтэй байдлыг бий болгож байна.

3.11. Бүх шатны ИТХ-аар хууль, тогтоомжид нийцсэн, иргэд олон нийтийн саналаар дэмжигдсэн, нийгэм, эдийн засгийн ач холбогдолтой, шаардлага хангасан төсөл, арга хэмжээг хэлэлцэн батлах шаардлагатай байна.

Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийн талаар:

3.12. Төрийн аудитын байгууллага нь Аудитын дээд байгууллагын олон улсын стандартын дагуу өмнөх аудитын тайланд дурдсан асуудал, зөвлөмжийн мөрөөр хариуцагч талын авч хэрэгжүүлсэн арга хэмжээний гүйцэтгэлд хяналт үнэлгээ хийх үүрэгтэй.

3.13. Өмнөх аудитаар аймгийн Засаг даргад 5 зөвлөмж хүргүүлснээс 2 нь хэрэгжиж, 1 зөвлөмж хэрэгжих шатандаа, 2 зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй, 56.5 хувьтай байна. (дэлгэрэнгүйг хавсралт №5-аас үзнэ үү)

ДҮГНЭЛТ:

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс болон аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт гаргаж байна.

- Татварын болон татварын бус орлогыг 1,425.2 сая төгрөгөөр нэмэгдүүлэх боломж байна.
- Бигэр, Бугат, Дэлгэр, Шарга сумын ИТХ-аас бүх малын тоо толгойн албан татварыг

24 Орон нутгийн чанартай наадам, ойг тэмдэглэхэд шаардагдах зардлыг энэ тогтоолын 1 дүгээр зүйлээр баталсан жишиг хэмжээгээр тооцон төсвөөс олгосон хөрөнгийн хэмжээнд багтаан хуваарилж байхыг аймгийн Засаг дарга нарт даалгасгай.



“0” төгрөг байхаар шийдвэрлэсэн байна.

- Төсвийн төсөлд урсгал зардлыг 66,975.6 сая төгрөг буюу төсвийн хязгаараас 7,991.2 сая төгрөгөөр хэтрүүлэн төлөвлөсөн байна.
- Урсгал зардлын төсвийг 4,094.4 сая төгрөгөөр бууруулахаар байна.
- Хөрөнгө оруулалтын зардлыг 2,760.0 сая төгрөгөөр бууруулахаар байна.
- Аймгийн ОНХС-гаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтыг нийтэд нээлттэй хэлэлцүүлээгүй, Засаг даргын зөвлөлөөр хугацаа хоцроож хэлэлцүүлсэн, иргэдээс санал аваагүй төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна.
- Төсвийн төслийг хууль тогтоомжид заасан зарчим, шаардлагын дагуу боловсруулах үйл ажиллагаа хангалтгүй байна.
- Төлөвлөсөн хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь хууль тогтоомжид заасан тусгай шаардлагыг хангахгүй, хүрэх үр дүн, нийгмийн ач холбогдол, эдийн засгийн үр ашиг, өгөөжийг тооцоогүй байна.
- Хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 3 төсөл, арга хэмжээ Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд тусгагдаагүй байна.
- Авто замын сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх чиг үүрэгт хамаарахгүй 1 төсөл, арга хэмжээг төлөвлөсөн байна.

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн, дүгнэлт нотлох зүйлст үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна.Үүнд:

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд толилуулах нь:

1. Аймгийн хөгжлийн төлөвлөгөөг төсвийн төсөл боловсруулахаас өмнө баталж байх.
2. Малын тоо толгойн албан татварын хувь хэмжээг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн тогтоох, төлөвлөх асуудлыг хянаж, биелэлтийг хангуулах ажлыг зохион байгуулах.
3. Хувьчлахаар баталсан хөрөнгүүдийн доод үнийг тогтоож, дуудлага худалдааг зохион байгуулж, хөрөнгийн асуудлыг шийдвэрлэх.
4. Төсвийн тухай хуульд заасан санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх, ил тод байдлыг хангах зарчмын хүрээнд төсвийг сахилга баттай, чангатгах, үр ашгийг дээшлүүлж, хууль тогтоомжийг мөрдүүлэх.
5. Хөрөнгө оруулалтын ажлуудыг төлөвлөхдөө урт, дунд хугацааны бодлогын баримт бичгүүдэд тусгасан, иргэдээс санал авсан, зураг төсөв, төсөвт өртгийг батлуулсан төсөл, арга хэмжээг батлах.

Аймгийн Засаг даргад:

1. Төрийн чиг үүргийг гэрээгээр гүйцэтгүүлэхдээ холбогдох хууль тогтоомжийн хүрээнд гэрээ байгуулж, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллах.
2. Урсгал засварын төсвийг ажлын зураг төсөв, тооцоо судалгаанд үндэслэн төлөвлөх.
3. Хөрөнгө оруулалтын ажлуудыг төлөвлөхдөө урт, дунд хугацааны бодлогын баримт бичгүүдэд тусгасан, иргэдийн санал авсан, зураг төсөв, төсөвт өртгийг батлуулсан төсөл, арга хэмжээг иргэд олон нийт, Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлдэг байх.



4. Төсвийн төслийг хууль тогтоомжид заасан төсвийн зарчим, шаардлагын дагуу боловсруулж, хавсралт баримт, тооцоо судалгааг бүрэн ирүүлж байх.

Сумдын Засаг дарга нарт:

1. Малын тоо толгойн албан татварын орлогын төлөвлөлтийг үндэслэлтэй төлөвлөж, биелэлтийг хангуулж ажиллах.
2. Хөрөнгө оруулалтын ажлуудыг төлөвлөхдөө урт, дунд хугацааны бодлогын баримт бичгүүдэд тусгасан, иргэдийн санал авсан, зураг төсөвтэй төсөл, арга хэмжээг төлөвлөх.



ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРААС САНАЛД ӨГСӨН ТАЙЛБАР

Төсвийн орлого:

Санал 1: Төсвийн тухай хуулийн 23.8. дах заалт "Сум, дүүрэг, орон нутгийн зэрэглэлтэй хот, тосгоны төсвийн татварын орлого дараах орлогоос бүрдэнэ:", 23.8.15-д "малын тоо толгойн албан татвар" гэж тус тус заасан байна. Иймд малд ногдуулах албан татварын хэмжээг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлан төсвийн орлогод төвлөрүүлэн, Төсвийн тухай хуулийн 60.2. дах заалт "Орон нутгийн хөгжлийн сан нь дараах эх үүсвэрээс бүрдэнэ:", 60.2.8.малын тоо толгойн албан татварын орлого. Уг орлогын эх үүсвэрийг бэлчээрийн даац тогтоох, бэлчээрийн төлөв байдлын үнэлгээ хийх, бэлчээр ашиглуулах гэрээний хэрэгжилтэд хяналт тавих ажлыг зохион байгуулах, газар тариалангийн усан хангамжийг нэмэгдүүлэх, малын эрүүл мэндийг хамгаалах, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, малын чанарыг сайжруулах, гэмт халдлага, гамшгаас хамгаалах, хур тунадасны хэмжээг нэмэгдүүлэх, малын тэжээлийн ургамал тариалах, тэжээлийн нөөц бүрдүүлэх, байгаль орчныг хамгаалах, хортон мэрэгчидтэй тэмцэх, малчдад зориулсан сургалт, сурталчилгааны зардалд зарцуулдаг. Иймээс аймгийн төсвийн орлогын төслийн зөрчлөөс хасаж өгнө үү.

Санал 1-д өгөх тайлбар: Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2-т "Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн удирдлагын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ" аймгийн Засаг даргын төсвийн талаарх үүргийг тодорхой заасан тул саналыг хүлээн авах боломжгүй байна.

Санал 2: Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор олгосон УИХ-ын гишүүдийн төслийн багцаас 2009-2012 онд олгосон зээлийн эргэн төлөлтөөс 2022 онд 39.1 сая төгрөг, 2023 онд 42.5 сая төгрөг, 2024 онд 19.5 сая төгрөг буюу нийт 101.1 сая төгрөг төлөгдсөн. Иймд 2025 онд 103.4 сая төгрөгийг төвлөрүүлэх боломжгүй тул бодитоор тооцож төлөвлөж өгнө үү.

Санал 2-д өгөх тайлбар: Өмнөх тооцоо судалгаан дээр үндэслэн тооцсон бөгөөд уг зээлийг төлүүлж төсвийг хохиролгүй болгох нь зүйтэй. Иймд саналыг хүлээн авах боломжгүй байна.

Төсвийн зарлага:

Санал 1: Аймгийн ИТХ-ын ажлын алба 1 авто машин нэмэгдсэн мөн аймгийн ИТХ-ын дэргэд 6 хороо ажиллаж байгаа тул шатахууны зардал өмнөх онуудаас нэмэгдсэн.

Санал 1-д өгөх тайлбар: Аймгийн ИТХ-ын дэргэдэх хороод өмнөх онуудад ажиллаж байсан бөгөөд тус байгууллагад 1 жолоочийн орон тоотой байна. Өмнөх онуудын гүйцэтгэлд үндэслэн, ирүүлсэн санал тайлбарыг үндэслэлгүй, тооцоо судалгаагүй байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хууль, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах"-ыг зөрчсөн гэж үзэн саналыг хүлээн авах боломжгүй.

Санал 2: Аймгийн ИТХ-ын 2021 оны 78 дугаар тогтоолын дагуу Боловсролын чанарыг сайжруулах хөтөлбөрт 2,500.0 сая төгрөг, Аймгийн ИТХ-ын 2024 оны 33 дугаар тогтоолын дагуу Төрийн албан хаагчдад орон сууцны дэмжлэг үзүүлэхэд 1,000.0 сая төгрөг, аймгийн ИТХ-ын 2023 оны 02 дугаар тогтоолын дагуу шинээр гэр бүл болсон малчин залуу өрхөд 50 толгой хүртэл бог малаар өмч тасалж өгөхөд 150.0 сая төгрөг, Жангар туйл хайлах, Жангар фестиваль, залуучуудын чуулга уулзалт зохион байгуулах арга хэмжээнд 200.0 сая төгрөг төлөвлөсөн бөгөөд дээрх шийдвэрүүдийг харгалзан хасаж өгнө үү.

Санал 2-д өгөх тайлбар: Урсгал зардлын төсвөөс хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлж байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Сангийн сайдын 2014 оны 55 дугаар тушаалаар баталсан "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар"-тай нийцэхгүй тул саналыг хүлээн авах боломжгүй.



Санал 3: Хүүхэд аюулгүй орчинд, бие даан сурч хөгжих нөхцөлийг бүрдүүлэхэд дэмжлэг 279.1 сая төгрөг төлөвлөсөн. (Төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх)

Санал 3-д өгөх тайлбар: Аймгийн ИТХ-ын шийдвэрийн дагуу төрийн чиг үүргийг гэрээгээр гүйцэтгүүлж, гэрээ байгуулан, холбогдох тооцоо судалгааг үндэслэлтэй боловсруулж, Сангийн яамаар хянуулсны үндсэн дээр баталж, санхүүжүүлэх зөвлөмжийг хүргүүлээ.

Санал 4: Зураг төсөв хийлгэж байгаа тул харгалзаж үзнэ үү

Санал 4-д өгөх тайлбар: Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4-т “Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана” гэж заасан тул саналыг хүлээн авах боломжгүй.

Санал 5: Эрчим хүчний зохицуулах хорооны 2024 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн 21 дугаар тогтоолоор баталсан тул хасаж өгнө үү.

Санал 5-д өгөх тайлбар: Аудитын явцад саналыг хүлээн авч, асуудлын бүртгэлээс хаслаа.

Санал 6: Аймгийн баяр наадмын зардлыг хасаж өгнө үү.

Санал 6-д өгөх тайлбар: Аудитын төгсгөлийн уулзалтаар уг асуудлыг давхардсан гэж хүлээн зөвшөөрсөн тул саналыг хүлээн авах боломжгүй.

Санал 7: Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчдийн үйл ажиллагаа, тэдгээрийг чадавхжуулах зардлыг Засгийн газрын 2024 оны 402 дугаар тогтоолын дагуу 195.0 сая төгрөгөөр төлөвлөсөн. Аймгийн Засаг даргын Тамгын газрын гадаад томилолтын зардлыг 200.0 сая төгрөг нэмэгдүүлсэн нь гадаад харилцааг өндөр түвшинд хөгжүүлнэ. хасаж өгнө үү.

Санал 7-д өгөх тайлбар: Аудитын төгсгөлийн уулзалтаар уг асуудлыг хэлэлцэн, хөтөлбөр батлагдсан тул харгалзан үзээд саналыг хүлээн авч, асуудлын бүртгэлээс хаслаа.

Төсвийн хөрөнгө оруулалт:

Санал 1: Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6 дахь заалт “иргэдээс санал авч дэмжигдсэн тохиолдолд Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагаанд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, өрхийн амьжиргааг дэмжих болон иргэдэд жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэхэд тоног төхөөрөмжийн болон арга зүйн дэмжлэг үзүүлэхэд чиглэсэн сургалтын төсөл, арга хэмжээг санхүүжүүлж болно” гэж заасны дагуу иргэдийн саналыг авсан, өрхийн амьжиргааг дэмжсэн уг төсөл арга хэмжээг төлөвлөсөн тул алдаа зөрчлөөс хасуулах саналтай байна.

Санал 1-д өгөх тайлбар: Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаал “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2-т “Аймаг, нийслэлийн ОНХС-ийн хөрөнгөөр Төсвийн тухай хууль болон энэхүү журмын хориглосон заалтад тусгагдаагүй дараах чиг үүргийн хүрээнд барилга байгууламж барих, тоног төхөөрөмж худалдан авах, их засвар хийх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг санхүүжүүлнэ”, 4.7.6-т “Аливаа аж ахуйн нэгж, байгууллага, иргэнд олгох буцалтгүй тусламж, дэмжлэг, тэтгэмж, урамшуулал” гэж заасныг зөрчсөн тул саналыг хүлээн авах боломжгүй.

Санал 2: Аймгийн Засаг даргын 2024 оны 2/936, аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын 2024 оны 3/752 тоот албан бичгээр сумдын Засаг даргын Тамгын газарт удаа дараа ОНХС-ийн төлөвлөлтийг хуулийн хугацаанд хийж, хууль журамд заасны дагуу холбогдох баримт бичгийн бүрдлийг ханган ирүүлэхийг үүрэг, чиглэл болгон ажилласан. Гэвч улс, орон даяар сонгуульт ажил



үргэлжлэн явагдсантай холбоотойгоор хуульд заасан хугацаанд төлөвлөлтийн төслийг хэлэлцээгүй хугацаа хоцроосон асуудлыг цаашид анхаарч, хууль, журамд заасан хугацааг мөрдөж ажиллана.

Санал 2-д өгөх тайлбар: Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаал “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 7.6-д “Ажлын хэсэг хэлэлцүүлгийн үр дүнг нэгтгэн аймаг, нийслэлийн ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний нэгдсэн жагсаалтыг ОНХС-ийн УМС-ийн маягтын дагуу хэвлэж жил бүрийн 8 дугаар сарын 10-ны өдрийн дотор Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлнэ” гэж заасныг зөрчсөн бөгөөд уг зөрчил жил бүр давтагдан гарсаар байна. Иймд саналыг хүлээн авах боломжгүй.

Санал 3: Алдаа зөрчлийн бүртгэлийн 4, 5 дугаар заалтад заасан зөрчлүүдэд урсгал зардлыг тооцоолоогүй гэх зөрчил байгааг хүлээн зөвшөөрөх боломжгүй байна. Учир нь тухайн төсөл арга хэмжээг хэрэгжүүлэх байгууллагуудаас уг төсөл арга хэмжээг төсөвт тусгуулах саналаа ирүүлсэн байгаагаар цаашдын ашиглалт, урсгал зардлыг хариуцах нь тогтоогдож байна. Иймд уг 2 заалтын утга агуулга давхардаж байгааг харгалзан зөрчлийг нэгтгэн, давхардлыг арилгуулах саналтай байна.

Санал 3-д өгөх тайлбар: Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3.6-т “орон нутгийн иргэдийн саналыг аваагүй, орон нутгийн төсвийн төлөвлөгөөнд тусгаж батлаагүй зардал, арга хэмжээ”, Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаал “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.1-д “Аймаг, нийслэлийн түвшинд дараах үндсэн нөхцөлүүдийг хангасан хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг ОНХС-ийн санхүүжилтээр хэрэгжүүлнэ” гэж заасан бөгөөд аудитаар баримт материалд дээрх мэдээллүүд ирээгүй тул саналыг хүлээн авах боломжгүй.

Санал 4: ОНТХО-аар хэрэгжүүлэхээр төлөвлөгдсөн Есөнбулаг сум “Говь-Алтай аймгийн Алтай хотын Лодойдамбын гудамжны тохижилт, шинэчлэлтийн ажил” нь 2 эх үүсвэрээс буюу ОНХС-аас санхүүжүүлж байгаа ажил тул нийт төсөвт өртгөөр зөрчлийг авч байгаа нь давхардал үүсч байгаа тул хүлээн зөвшөөрөх боломжгүй байна. Мөн Есөнбулаг сум “Говь-Алтай аймгийн Алтай хотын Лодойдамбын гудамжны тохижилт, шинэчлэлтийн ажил”, Есөнбулаг сумын гэр хорооллын багт ус түгээх цэг байгуулах ажлууд нь аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 2.5.2, 2.5.4, 6.3.1-д тус тус тусгагдсан байгаа тул зөрчлөөс хасуулах саналтай байна.

Санал 4-д өгөх тайлбар: Аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд дээрх 2 төсөл арга хэмжээ тусгагдсан тул асуудлын бүртгэлээс хаслаа. Харин аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд “Солонго дулааны станц” ААТҮГ-т эко хашаа шинээр барьж байгуулах ажил тусгагдаагүй тул хасах боломжгүй байна.

Санал 5: Авто замын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1, 4.1.11, дэх хэсэгт заасны дагуу авто зогсоол нь авто замын байгууламжид орж байгаа тул тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт заасны дагуу санхүүжүүлэх боломжтой гэж үзэж байгаа тул уг зөрчлөөс хасуулах саналтай байна.

Санал 5-д өгөх тайлбар: Авто замын тухай хуулийн 24.4-т “Авто замын сангийн хөрөнгөөр авто замын арчлалт, урсгал засвар, гэнэтийн хүчин зүйлээс хамаарсан засварын ажлыг тэргүүн ээлжинд санхүүжүүлнэ.”, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 312 дугаар тогтоолоор “Авто замын санд хөрөнгө төвлөрүүлэх, захиран зарцуулах журам” -ны 3.2-т “Авто замын сангийн хөрөнгийг Авто замын тухай хуулийн 24 дүгээр зүйлд заасны дагуу авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, аймаг, нийслэлийн Засаг дарга тус тус зориулалтын дагуу захиран зарцуулна” гэж заасантай нийцэхгүй тул саналыг хүлээн авах боломжгүй.



A blank sheet of lined paper with horizontal ruling lines.